

## 1. Altitude, height, level and elevation - үгсийн орчуулгын талаар

2010 оноос мөрдөж байсан үндсэн 48 ИНД-д “өндөр” гэж 883 удаа орсон. Үүнээс:

- “харьцангуй өндөр” 26,
- “үнэмлэхүй өндөр” гэж 52 удаа ашигласан байна.

ИНД-д 805 удаа (883-(52+26)) дан “өндөр” гэж орчуулсан нь height, altitude, level, elevation-ийг харьцангуй, эсхүл үнэмлэхүй өндрийн аль болохыг ойлгомжгүй болгосон буюу height, altitude, level, elevation гэдэг үгсийг аль алиныг нь “өндөр” гэдэг нэг үгээр орчуулан хэрэглэж байсан.

Хуучин ИНД-д “өндөр”-ийг харьцангуй, үнэмлэхүй гэж орос хэлнээс буулган хэрэглэж байсан боловч хооронд нь андуурч, хольсон ба height, altitude, level, elevation гэдэг үгс болон түүнтэй холбоотой DA/DH, TA/TH, MDA/MDH ойлголтуудыг алдаатай, тодорхойгүй байдлаар тусгасан байна.

Англи дүрмийн эх үүсвэрт		2010 оны ИНД	
altitude - 19 ИНД-д	299 удаа	<b>үнэмлэхүй өндөр</b> - 6 ИНД-д 52 удаа	бусдыг “өндөр” гэж оруулсан
height - 21 ИНД-д	186 удаа	<b>харьцангуй өндөр</b> - 5 ИНД-д 26 удаа,	бусдыг “өндөр” гэж оруулсан
flight level - 7 ИНД-д	64 удаа	2010 оны ИНД-д <b>flight level</b> гэдэг үгийг дараах байдлаар, 8 янзаар орчуулсан байдаг: <ol style="list-style-type: none"> <li>1. Нислэгийн түвшин (ИНД-1, Cruising level / Чиг шулуун нислэгийн түвшин)</li> <li>2. Нислэгийн <b>өндөр</b> (ИНД-1, 133, 135, 172, 175, 43, 61, 71, 91)</li> <li>3. Нислэгийн <b>өндрийн</b> цуваа (ИНД-1, 91)</li> <li>4. Нислэгийн <b>өндрийн</b> цуваачлал (ИНД-91)</li> <li>5. Нислэгийн цуваа (ИНД-104, 172, 71, 73, 75, 95)</li> <li>6. Нислэгийн цуваачлал (ИНД-172)</li> <li>7. <b>Өндрийн</b> цуваачлал (ИНД-91)</li> <li>8. Цувааны <b>өндөр</b> (ИНД-91)</li> </ol>	
Elevation - 7 ИНД-д	28 удаа	<b>өндөр</b>	

## 2. 2010 оны ИНД-91-д нийт 266 “өндөр” гэсэн үг хэрэглэсэнээс:

2010 оны ИНД	тоо	Англи	Шинэлчилсэн ИНД
<b>өндөр</b> хэмжигч	16	altimeter	алтиметр
аюулгүй <b>өндөр</b>	6	minimum heights	минимум өндөр
аюулгүй нам <b>өндөр</b>	24	minimum altitudes	минимум түвшин
шилжих <b>өндөр</b>	7	transition altitude	шилжих түвшин
<b>өндрийн</b> цуваачлал	4	flight level	нислэгийн түвшин
нислэгийн <b>өндрийн</b> цуваачлал	3		
цувааны <b>өндөр</b>	4		
<b>өндрийн</b> цуваа	9		
<b>нислэгийн түвшин</b>	2		
нислэгийн <b>өндөр</b>	22	altitude	түвшин
шийдвэр гаргах үнэмлэхүй өндөр	6	DA (decision altitude)	шийдвэр гаргах түвшин
шийдвэр гаргах харьцангуй өндөр	11	DH (decision height)	шийдвэр гаргах өндөр
<b>шийдвэр гаргах өндөр</b>	16	decision height / decision altitude	
<b>өндөр</b>	130	136 удаа дан “өндөр” гэж орчуулсан нь height, altitude-ийг харьцангуй, эсхүл үнэмлэхүй аль болох нь ойлгомжгүй хэрэглэсэн.	

Англи ИНД-91-т:	2010 оны ИНД-91-т:
- Altitude-111 удаа, - Height-33 удаа,	- үнэмлэхүй өндөр-23 удаа - харьцангуй өндөр-3 удаа
Нийт 26 удаа “үнэмлэхүй болон харьцангуй өндөр” гэж ялгасан ба үлдсэн 118-г “өндөр” гэж орчуулсан нь height, altitude-ийг харьцангуй, эсхүл үнэмлэхүй өндрийн аль болох нь ойлгомжгүй хэрэглэсэн.	

### 3. Шинэ болон хуучин ИНД-д height, altitude, level гэдэг үгсийг хэрэглэсэн байдал

(улаан өнгөөр 2010 оны ИНД-д буруу хэрэглэсэн жишээ, цэнхэр өнгөөр 2021 оны ИНД-д нэгтгэж хэрэглэсэн жишээ)

Altitude - түвшин	Height - өндөр	Level - түвшин
cruising altitude (12) <b>аяллын түвшин (12)</b> <i>чиг шулуун нислэгийн үнэмлэхүй өндөр</i>		cruising level (18) <b>аяллын түвшин (18)</b> <i>чиг шулуун нислэгийн түвшин (ИНД-1)</i>
altitude <b>түвшин</b> <i>үнэмлэхүй өндөр</i>	height flown <b>нисэж байгаа өндөр</b> <i>нисэж байгаа харьцангуй өндөр</i>	flight level - (FL) <b>нислэгийн түвшин</b> <i>нислэгийн өндрийн цуваа (нислэгийн түвшин, нислэгийн өндрийн цуваачлал, цувааны өндөр г.м)</i>
safe altitude (8) <b>аюулгүй түвшин (8)</b> <i>аюулгүй үнэмлэхүй өндөр (6)</i>	safe height (3) <b>аюулгүй өндөр (3)</b> <i>аюулгүй харьцангуй өндөр (Ө 12)</i>	ground level <b>газрын түвшин</b> <b>газрын түвшин</b>
pressure altitude (47) <b>даралтын түвшин (43)</b> sensitive pressure altitude-4 <i>даралтын үнэмлэхүй өндөр (4)</i>	pressure height <b>даралтын өндөр</b> <i>даралтын харьцангуй өндөр</i>	sea level <b>далайн түвшин</b> <b>далайн түвшин</b>
decision altitude - DA <b>шийдвэр гаргах түвшин</b> <i>шийдвэр гаргах үнэмлэхүй өндөр</i>	decision height - DH <b>шийдвэр гаргах өндөр</b> <i>шийдвэр гаргах харьцангуй өндөр</i>	AMSL <b>далайн дундаж түвшнээс дээш</b> <b>далайн дундаж түвшнээс дээш</b>
transition altitude - TA <b>шилжих түвшин</b> <i>шилжих үнэмлэхүй өндөр</i>	transition height - TH <b>шилжих өндөр</b> <i>шилжих харьцангуй өндөр</i>	AGL <b>газрын түвшнээс дээш</b> <b>газрын түвшнээс дээш</b>
minimum descent altitude - MDA <b>өндөр алдах минимум түвшин</b> <i>доошилж болох хамгийн бага үнэмлэхүй өндөр</i>	minimum descent height - MDH <b>өндөр алдах минимум өндөр</b> <i>доошилж болох хамгийн бага харьцангуй өндөр</i>	

#### 4. Шинэ болон хуучин ИНД-д орсон height, altitude, level, elevation-ийн тодорхойлолт

Англи	Хуучин ИНД-1	Шинэ ИНД-ийн нэр томъёоны тайлбар
<b>Height</b> means the vertical distance of a level, a point, or an object considered as a point, measured from a specified datum and includes the vertical dimension of an object:	<b>Height / Харьцангуй өндөр</b> <i>Тодорхой тогтоосон түвшингээс тухайн цэг буюу объект, эсхүл түвшин хүртэлх босоо зай.</i>	<b>Өндөр / Height</b> гэж тусгайлан тогтоосон эхлэлийн цэгээс хэмжсэн бөгөөд тухайн байгууламжийн босоо хэмжээг багтаасан, түвшин, цэг, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зайг;
<b>Altitude</b> means the vertical distance of a level, a point, or an object considered as a point, measured from mean sea level:	<b>Altitude / Үнэмлэхүй өндөр</b> <i>Далайн дундаж түвшнээс тухайн цэг, объект, эсхүл түвшин хүртэлх босоо зай.</i>	<b>Түвшин / Altitude</b> гэж далайн дундаж түвшнээс хэмжсэн, түвшний, цэгийн, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зайг;
<b>Level</b> is a generic term relating to the vertical position of an aircraft in flight and meaning variously height, altitude, or flight level:	<b>Level / Өндрийн түвшин</b> <i>Нислэг үйлдэж буй агаарын хөлгийн байршиллын босоо зайн ерөнхий томъёолол бөгөөд харьцангуй ба үнэмлэхүй өндөр, эсхүл нислэгийн өндрийн цуваа гэсэн ухагдахуунуудаар илэрхийлэгдэнэ.</i>	<b>Түвшин / Level</b> гэж нислэгт байгаа агаарын хөлгийн босоо байршилтай холбоотой өндөр, түвшин, эсхүл нислэгийн түвшнийг илэрхийлдэг ерөнхий ойлголтыг;
<b>Flight level</b> means a surface of constant atmospheric pressure expressed in terms of hundreds of feet that- (1) is related to a specific datum 1013.2 hPa; and (2) is separated from other such surfaces by specific pressure intervals:	<b>Flight level / Нислэгийн өндрийн цуваа</b> <i>Атмосферийн 1013.2 гПа тогтмол даралтын түвшингээс тооцсон, Монгол Улсын AIP-д зарлагдсан нислэгийн тодорхой өндөр.</i>	<b>Нислэгийн түвшин / Flight level</b> гэж зуун фитийн утгаар илэрхийлдэг, атмосферийн тогтмол даралтын дараах гадаргууг: (1) тусгайлан тогтоосон 1013.2 hPa (760 мм м.у.б) даралтын цэгээс эхэлдэг; (2) бусад даралтын гадаргуугаас тусгайлан тогтоосон даралтын үечлэлээр зайчлагддаг:
<b>Elevation</b> means the vertical distance of a point or a level, on or affixed to the surface of the earth, measured from mean sea level:	<b>Elevation / Өндөр</b> <i>Далайн дундаж түвшнээс газрын гадаргуу, эсхүл аливаа цэг, түвшин хүртэлх босоо зай.</i>	<b>Өндөрлөг / Elevation</b> гэж далайн дундаж түвшнээс хэмжсэн, газрын гадаргуу дээр, эсхүл түүнд бэхэлсэн цэгийн, эсхүл түвшний босоо зайг; ( <i>Газрын зурагт “өндрийн тэмдэглээ” гэж бас хэрэглэдэг</i> )

#### 5. Cruise, cruising гэдэг үгсийг хэрэглэсэн байдал

Англи	Хуучин ИНД	Шинэ ИНД
Cruise relief pilot	<i>Чиг шулуун нислэг дахь ээлжийн нисгэгч (багийн нэмэгдэл гишүүн)</i>	Аяллын орлон нисгэгч
Cruising level	<i>Чиг шулуун нислэгийн ТҮВШИН</i>	Аяллын түвшин
Cruising altitude	<i>Чиг шулуун нислэгийн өндөр, нислэгийн үнэмлэхүй өндөр</i>	Аяллын түвшин
Cruising speed	<i>Нислэгийн хурд</i>	Аяллын нислэгийн хурд
Straight and level flight	<b>Чиг шулуун нислэг</b>	Чиг шулуун нислэг
En-route	<i>Чиг шулуун нислэг</i>	Нислэгийн замын дагуух
Хуучин ИНД “cruising flight”-г “горизонталь полёт буюу хэвтээ нислэг” гэдэг үгийг орчуулахдаа “чиг + шулуун нислэг” гэж “straight and level flight” гэдэг үгтэй адил хэрэглэсэн. Аяллын нислэгт агаарын хөлөг нь heading & flight level-ээ тогтмол өөрчилдөг тул “cruising flight” нь “чиг шулуун нислэг” биш.		